



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Юу би ай эн эн ХХК-ийн “Юу би ай эн эн” зочид буудлын 18/175, Мон девелопмент ХХК-ийн “Вайт хаус” зочид буудлын 18/227, РЭАБ ХХК-ийн “Говь люкс” зочид буудлын 17/211, Вест төв ХХК-ийн “Мейсон” зочид буудлын 18/224, Гамба ХХК-ийн “Хорека” зочид буудлын 18/252,


1150500240


Мөнххаан мөнх ХХК-ийн “Мөнххаан” зочид буудлын 18/30, Грийт Монголиан винд экспедишн ХХК-ийн “Вандер Монголиа” дэн буудлын 18/214, Хаан шонхор ХХК-ийн “Хаан шонхор” дэн буудлын 18/177, Огторгуйн цаг ХХК-ийн “Хас” дэн буудлын 18/133 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон /-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 06
сарын 11 өдрийн А/44 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1115263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.06.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Юу би ай эн эн ХХК	5571251	Юу би ай эн эн	ЧД-ийн, 5-р хороо, Самбуугийн гудамж 35
2	Мон девелопмент ХХК	2804433	Вайт хаус	БГД-ийн, 17-р хороо, Дамдинбазарын гудамж
3	РЭАБ ХХК	5496802	Говь люкс	БЗД-ийн, 20-р хороо, Даваатын ам
4	Ачмон ХХК	2577445	Мейсон	СБД-ийн, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 13-2
5	Гамба ХХК	2829282	Хорека	БЗД-ийн, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 79
6	Мөнххаан мөнх ХХК	5500435	Мөнххаан	БГД-ийн, 4-р хороо, Замчдын 7/3 тоот
7	Молор трейд ХХК	2571889	Тамир	БГД-ийн, 13-р хороо, 3-р хороолол Ард Аюушийн өргөн чөлөө 16Б
8	Сэлэнгэ маяк ХХК	5599113	Славянка	БЗД-ийн, 4-р хороо, Сэлэнгэ зочид буудал
9	Чингис хаан цогцолбор ХХК	2095238	Чингис хаан	БЗД-ийн, 1-р хороо, Токиогийн гудамж 10

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 06
сарын 11-өдрийн А/44 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ-8936 1115263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2019.06.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Вандер Монголиа гэст хаус энд тур оператор ХХК	5912717	Вандер Монголиа	СБД-ийн, 4-р хороо, Юб таун хотхоны 38-р байр 85 тоот
2	Хаан шонхор ХХК	2541289	Хаан шонхор	БЗД-ийн, 18-р хороо, 13-р хороолол 45
3	Огторгуйн цаг ХХК	5064635	Хас	БГД-ийн, 20-р хороо, Товчооны зам 25-2

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 06
сарын 11 өдрийн А/44 дүгээр
тушаалын гурвдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.06.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ноён ХХК	2008386	Ноён	БД-ийн, 5-р хороо, Хэрлэн голын хөвөөнд

-ooOoo-